

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Зөрчлийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хүний эрх, хүүхэд, эмэгтэйчүүд, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагын төлөөлөл, судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор 2014 оны 1 дүээр сард зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцогчдоос гарсан санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс судлаач Ц.Ариунболд, Х.Билгүүнзаяа, Ж.Даваасүрэн, М.Туяа, Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбооноос өмгөөлөгч М.Жаргалсайхан, Ш.Жаргалсайхан, Х.Номинцэцэг, В.Ганболд, С.Оюун болон бусад ТББ-аас Ц.Батсайхан (НДЭХ-ий Төв аймгийн салбар зөвлөл), Б.Баттогтох (МонАме судалгааны төв), Ш.Гансүрэн (Ирээдүйн босго), А. Долгор (Хөгжлийн хэлхээ), Г.Итгэл (Монголын эрх зүйчдийн холбоо), Ш.Ахагвасүрэн (Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг), Т.Маамуу (Өв тэгш хөгжлийг дэмжих сан), Д.Мөнхнасан (АГБТ төв), Д.Мөнхцэцэг (Ирээдүйн босго), Д.Отгонцэцэг (Хүүхэд өмгөөлөл төв), Ц.Оюунбаатар (Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо), Д.Цэнд-Аюуш (Хууль, хүний эрх төв), Н.Шажинбат (И Эл Си нөхөрлөл), Ч.Энхмандах (Хил хязгааргүй алхам) болон Б. Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) нар оролцсон юм.

- ☑ Хуулийн төслийн 1.3.2-т хариуцлага хүлээлгэх субъектийг «хувь хүн, хуулийн этгээд» гэж тодорхойлсон боловч тусгай ангийн 9.7.1, 16.1.7 зэрэг зүйлд «албан тушаалтан» гэж заасан нь зөрчилтэй байна.
- ☑ Торгох шийтгэлийн мөнгөн дүнг шууд заасан нь оновчтой биш зохицуулалт гэж үзэж байгаа бөгөөд энэ нь хуулийн төслийн 1.3.2-т заасан зарчимд үл нийцнэ. Урт хугацаандаа мөнгөний ханш өөрчлөгдөх явцад тухайн зөрчилд ногдуулах торгох шийтгэл хөнгөрч байгаа бол бусад шийтгэлийн тухайд энэхүү өөрчлөлт байхгүй тул нэг зөрчилд шийтгэл авч байгаа хүмүүст ялгамжтай байдал бий болж байна. Мөн адилхан зөрчил үйлдэж торгох шийтгэл авсан хүмүүст цаг хугацаанаас хамааран торгох шийтгэлийн хэмжээ өөр өөр үр дагавар үүсгэхээр байгаа юм.

Санал: Тиймээс торгох шийтгэлийн хэмжээг мөнгөний ханшийн өөрчлөлттэй уялдуулан зохицуулах нь зүйтэй гэж үзлээ. Түүнчлэн, торгох шийтгэлийн хэмжээг хуулийн этгээдэд оногдуулахдаа тухайн үйл ажиллагаанаас олсон орлоготой нь уялдуулан тогтоох замаар зөрчилд оногдуулах шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх боломжтой.

- ☑ Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нь хариуцлагын хүнд хэлбэр байтал баривчлах, цагдан хорих нэг хоногийг дүйцүүлэн тооцсон мөнгөний дүн хэтэрхий бага байна.

Санал: Хуулийн төслийн 3.3.3-т «Баривчлагдсан, цагдан хоригдсон нэг хоногийг торгуулийн хорин мянган төгрөгтэй дүйцүүлэн тооцно» гэсэн заалтад байгаа мөнгөн дүнг өсгөх

☑ Хуулийн төслийн 3.6.2-ын зорилго, үр дагавар ойлгомжгүй байна. Уг зүйлд «... Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол тухайн зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш нэг жилийн хугацаанд дахин олгохгүй» гэж заасан. Эндээс харахад, тусгай зөвшөөрлийг нэг жилээс дээш хугацаагаар хүчингүй болгосон байхад нэг жил өнгөрснөөр үүнийг сэргээж болохоор байна.

☑ Нийгмийн харилцаанд сэтгэцийн эмгэг, оюуны бэрхшээлтэй хүнийг өөрийн зүй бус зорилгод ашиглах тохиолдол гарах болсон хэдий ч энэ төрлийн зөрчилд буруутай этгээд хариуцлага хүлээдэггүй.

Санал: Тиймээс хуулийн төслийн 3.2-р зүйлд «сэтгэцийн эмгэг, оюуны бэрхшээлтэй хүнийг өөрийн зүй бус зорилгод ашигласан этгээдэд хариуцлага хүлээлгэх» талаар заалт нэмэх

☑ Хуулийн төслийн 7.8.4 «устгахаар шийдвэрлэсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулсан, эсхүл зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулсан», 7.8.5 «Хуулиар хориглосон ажлын байранд эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй ажилтанг ажиллуулсан» гэсэн нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, устгахаар шийдвэрлэсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг «зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулах» гэж юу болох, «хуулиар хориглосон ажлын байр» гэж ямар ажлын байрыг хэлэх, хуулиар хориглосон бол ажилтан нь яагаад заавал «эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан» байх ёстой, ямар үйлдлийг зөрчилд тооцох зэрэг нь ойлгомжгүй байна.

☑ Хүмүүсийн өдөр тутмын амьдралд байнга тохиолддог үйлдлүүдийг зөрчилд хамруулаагүй байна. Тухайлбал, нийтийн орон сууцанд оршин суугч их дуу чимээ гарган хөрш айл өрхийн амар тайван байдлыг алдагдуулах, орон сууцны гаднах талбайд шөнийн цагаар их дуу чимээ гаргах зэрэг үйлдлийг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэх шаардлагатай юм.

Санал: Тиймээс 8.7-д «Нийтийн орон сууцанд иргэний амар тайван, аюулгүй байдлыг алдагдуулсан» гэсэн агуулга бүхий заалт нэмэх

☑ «Хүүхдээ хувцас, хоол хүнс, орон байраар гачигдуулсан ...» тохиолдолд шийтгэл хүлээлгэх нь зүй ёсны хэдий ч үүнийг илүү тодорхой зааж өгөх шаардлагатай юм.

Санал: 6.1.1-д «хүүхдийн хувцас, хоол хүнс ...» гэсний өмнө «зориудаар» гэсэн үг нэмэх

☑ Хуулийн төслийн 4.4-т хохирлын нөхөн төлбөрийг улсын орлого болгоно гэж заажээ. Зөрчил гаргасан этгээдээс гаргуулан авч буй нөхөн төлбөр нь угтаа хохирлыг арилгахад чиглэгдэх ёстой. Гэтэл дээрх заалтаас үзэхэд энэ зорилгыг хангаж чадах эсэх нь эргэлзээ үүсгэж байна.

Санал: 4.4-т «... улсын орлого болгоно» гэснийг «хохирлыг нөхөн төлөх санд төвлөрүүлэх эсхүл хохирлыг нөхөн төлнө» гэж өөрчлөн найруулах

☑ Зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага оновчтой биш байгаа нь зарим зөрчлийн хувьд ажиглагдаж байна.

Санал: 8.1.6-ийн торгох шийтгэлийн хэмжээг иргэн, хуулийн этгээдэд ялгаатай ногдуулах; 5.1.1, 7.1.7, 7.3.1, 7.3.2, 7.5.2, 8.1.2, 9.1.2, 9.5.1, 12.2.8, 13.4.1-4, 14.4.5, 14.5.7, 17.23.2, 17.22.5, 17.42.1 зүйлд заасан зөрчилд хүлээлгэх торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, харин 9.5.1-ийн иргэнд ногдуулах торгуулийн хэмжээг багасгах, 7.1.7, 7.10.2-д «эрх хасах, хязгаарлах» шийтгэлийг нэмэх; 9.1.2, 9.3.1, 9.3.2, 9.3.4, 9.11.2, 13.5, 17.19.4 зүйлүүдэд заасан зөрчлийг гэмт хэрэгт тооцож, Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгах

- Иргэн, хуулийн этгээд нь эрчим хүч ашигласны төлбөрөө хугацаанд нь бүрэн гүйцэд төлөх нь «гэрээний үндсэн дээр бий болсон үүрэг» буюу иргэний эрх зүйн харилцаа бөгөөд гэрээний нэг тал нь нөгөө талаа гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзвэл учирсан хохирлоо барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг.

Санал: Тиймээс 9.6.4 заалтыг хуулийн төслөөс хасах

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг баталгаажуулах зарим зохицуулалт шаардлагатай байна.

Санал: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулах, хангах хүрээнд баталсан стандарт, норм, дүрмийг зөрчсөн үйлдэлд шийтгэл ногдуулах тухай шинэ заалт нэмэх

- «Ус», «байгалийн ургамал» зэрэг үгийг ямар нэг хязгаарлалтгүйгээр ахуйн хэрэгцээнд ашигладаг «ус, ургамал»-аас ялгаагүй байдлаар тодорхойлсон нь хуулийг хэрэглэх явцад хүндрэл учруулахаар байна. Тухайлбал, хуулийн төслийн 14.6, 14.12-р зүйлийг дурьдаж болно. Учир нь байгалийн ургамал гэдэгт ховор, нэн ховор ургамлын аль алийг хамруулдаг тул байгальд элбэг ургадаг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр ахуйн хэрэгцээнд ашигладаг ургамлыг үүнд хамруулан үзэхэд хүргэж байна. Мөн 14.12-т «ус» гэж заасан бөгөөд ахуйн хэрэгцээний ус уу, үйлдвэрийн ус уу гэдэг нь тодорхойгүй байгаа юм. Мөн 16.1.2-т «Олон нийтийн газар» гэсэн ч ямар газрыг олон нийтийн газар гэж үзэх нь тодорхойгүй байна.

- Биеэ үнэлэгчид шийтгэл ногдуулж байгаа хэрнээ түүнийг худалдан авсан хүнд шийтгэл ногдуулахгүй байгаа нь энэ төрлийн зөрчил буурахгүй байх шалтгаан мөн.

Санал: 16.4-т «Биеэ үнэлэгчийг худалдан авсан хүнийг торгох» агуулга бүхий заалт нэмэх

- Жагсаал, цуглаан зохион байгуулагчдын эрхийг хамгаалах зохицуулалт үгүйлэгдэж байна.

Санал: Тиймээс 16.5-д «Жагсаал цуглаан зохион байгуулахад түүнийг хамгаалах үүргээ биелүүлээгүй» гэсэн заалт нэмэх

- Аялал жуулчлалын байгууллага нь үйлчилгээний ажилтнуудаа мэргэжлийн сургалт, дамжаанд хамруулах эсэх нь тухайн байгууллагын дотоод асуудал билээ.

Санал: Тиймээс 17.42-ыг хуулийн төслөөс хасах

- Түүнчлэн хуулийн төсөлд заасан зарим зөрчил хор уршиг учруулах нь зайлшгүй байтал энэ тохиолдолд хор уршигийг хэрхэн яаж арилгах талаар тодорхой зохицуулалт хуулийн төсөлд тусаагүй байна

Санал: «хор уршигийг арилгах» тухай зохицуулалтыг заавал тусгах шаардлагатай бөгөөд хор уршигийг арилгаснаар шийтгэлээс хөнгөрүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах

- Хуулийн төсөлд «юүтгэл», «агсамж», «мэргэжлийн шарлагын хувийн тун», «зохистой дадал» зэрэг нийтэд ойлгомжгүй нэр томъёо хэрэглэсэн боловч тайлбарлаагүй байна. Хуулийн төсөлд үг, үсгийн болон зүйл, заалтын утга найруулгын алдаа нэлээдгүй байгаа нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасан «нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих» гэсэн шаардлагад нийцэхгүй байна.

Санал: Хуулийн төслийн үг, үсэг, утга найруулгын алдаа, ойлгомжгүй нэр томъёо, заалтыг хуулийн төслийн техникийн шаардлагад нийцүүлэн засч сайжруулах. Хуулийн төслийн 1.2, 2.1.1, 2.1.2 зүйлүүдэд заасан «хуулиар эрх олгосны дагуу хэм хэмжээ тогтоосон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг» гэснийг Захиргааны ерөнхий хуулийн төсөлд нийцүүлэн «захиргааны хэм хэмжээний акт» гэж өөрчлөн найруулах (хууль зүйн техникт энэ утгаар ойлгогдож хэвшсэн)

Хуулийн төсөлд утга, найруулга, үг үсгийн алдааг залруулах, оновчтой томъёолох шаардлагатай тодорхой заалтууд байна.

Санал:

- 2.6.2-ын «...Түүний ойлгосноор үйлдсэн байх ёстой газар» гэсэн нь ойлгомжгүй байгаа тул өөрчлөн найруулах; Мөн 5.1-ийг «Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам зөрчих» гэж, 7.8.3-д «... хуульд заасан үе шатад зохистой дадлыг нэвтрүүлээгүй ...» гэснийг «үйлдвэрлэлийн стандарт мөрдөөгүй» гэж, 2.4.2 заалтыг «Гарцаагүй байдалд үйлдэж учруулсан хохирол нь тулгарсан аюулын улмаас учирч болох байсан хохирлоос илүү байвал гарцаагүй байдлын хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ» хэмээн тус тус өөрчлөн найруулах;
- 5.6.2-оос «албан ёсоор цуцлаагүй», 16.7.1-д «... садар, самуун», 17.27.2-т «... тусгахыг» гэсний дараа «... хориглох» гэснийг тус тус хасах;
- 5.6.4-т «... зохих бичилт хийж баталгаажуулаагүй» гэсний дараа «,албан ёсоор цуцлаагүй» гэж, 6.1.6-д «... зөрчил гаргасан сурагчийн» гэсний дараа «эцэг, эх, асран хамгаалагчийг ...» гэж, 7.8.2 «... шошгод тавих шаардлага хангаагүй, шошгыг орчуулаагүй» гэж, 9.11.1 «... нэг зуун» гэсний дараа «... мянган» гэж, 14.1.4-т «... гурван зуун» гэсний дараа «... мянган» гэж, 14.5.6-д «... худалдсан, худалдан авсан» гэсний дараа «захиалсан» гэж, 16.5.2-т «...сэтгэцийн өвчтэй» гэсний дараа «... хөгжлийн бэрхшээлтэй» гэж, 17.3.1-д «... борлуулсан» гэсний дараа «... эрх шилжсэн үед тамга, тэмдгээ шилжүүлж өгөхгүй байх, нуух» гэж, 17.27.2-т «... түүнд оролцох, санхүүжүүлэх» гэсний дараа «... бол» гэж, 17.38.1 «... тэмдэгтийг өөрчилж, гэмтээсэн,» гэсний дараа «... бол» гэж, 17.25.2-т «... заавал хамруулах журам зөрчсөн» гэсний дараа «... бол» гэж, 17.39.3 «... ажилд авсан» гэсний дараа «... бол» гэж тус тус нэмэх;
- 7.8.5-д «... торгор» гэснийг «... торгох» гэж, 15.7-д «...шууд зардал» гэснийг «...бодит зардал» гэж, 16.2.2-д «Хууль сахиулагч хэрэглэх эрхтэй тусгай хэрэгсэл» гэснийг «зөвшөөрөлгүйгээр» гэж, 16.5.1-д «... бүртгэлгүйгээр» гэснийг «... эрх бүхий байгууллагад мэдэгдэлгүйгээр» гэж, 17.39.2 «... хэтрүүлэн байлгасан» гэснийг «... хэтрүүлсэн» гэж, 16.7.1-д «... алан хядлага» гэсэн нь хуульд оновчтой биш тул «... дайны» гэж тус тус өөрчлөх;
- 17.6-ын гарчигт «Статистикийн» гэснийг «Статистикийн» гэж, 17.11.1-д «... эзэмшүүлэх» гэснийг «... эзэмшүүлэх» 16.6-д «... зяян» гэснийг «зуун» гэж засах.

Зүйлийн нэр нь заалтад тусгагдсан агуулгатайгаа нийцээгүй зарим зөрчил байна.

Санал: Хуулийн төслийн 4.1-ийн нэрийг «эд зүйл, орлого хураах» гэж, 15.13-ын нэрийг «Цол, одон медаль, нийтийн албан хаагчийн дүрэмт хувцас өмсөх» гэж өөрчлөн найруулах

Хуулийн төслийн зүйл, заалт хоорондоо давхцсан байна.

Санал: 17.41 нь 17.1-тэй давхцаж байгаа тул хуулийн төслөөс хасах.

17.6-17.10 дахь заалтын дугаарлалт алдаатай байгаа тул залруулах.

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын
хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn